



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/949

Мандалговь

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах, хяналт тавих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.11 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчний эрсдэл бүхий Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь аймгуудаас гоц халдварт өвчний шинжилгээний бичиггүй мал, амьтан хүлээн авахыг 2021 оны 09 сарын 01-ны өдөр хүртэл хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнөөр ирсэн сүрэгт үзлэг хийж, сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийн эмчийг мэргэжил арга зүйн зөвлөгөө, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Мал амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаас ирсэн мал, амьтныг нэвтрүүлэхдээ мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон шимэгчлэх өвчнөөс эмчлэх сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан сүрэгт үзлэг хийж, /адуунд нийлүүлэг, ям/ бусад малд шүлхий болон бог малын мялзан, бруцеллёзын шинжилгээний бичигтэй тохиолдолд нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар, Сумдын Засаг дарга, мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт үүрэг болгосугай

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА  Ц. МӨНХБАТ



481210057